

**Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны  
03 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ**

2024 оны 03 дугаар сарын 22

Дархан-Уул аймаг

2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шарын гол сумын 17, 25-р цэцэрлэгийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль эрх зүйн актын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх зорилгоор санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар 17-р цэцэрлэгт 23,225.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 12,736.6 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, 3,686.6 мянган төгрөгийг ажилтанд олгуулахаар Улсын ахлах байцаагчийн акт тогтоож, 6,801.9 мянган төгрөгийн зөрчил арилгуулахаар Улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлээ.

Мөн 25-р цэцэрлэгт илэрсэн зөрчилд Улсын ахлах байцаагчийн 5 актаар 1,117.0 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, 61,028.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага тус тус өглөө.

Дотоод аудитыг Дархан сумын 8, 10 дугаар цэцэрлэгт хийлээ. 8 цэцэрлэгийн дотоод аудитаар илэрсэн зөрчилд 1,105.8 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн 7 акт тогтоож, 33,329.1 мянган төгрөгийн зөрчилд Улсын ахлах байцаагчийн албан шаардлага, 12 зөвлөмж хүргэлээ. Мөн 10 цэцэрлэгийн дотоод аудитаар илэрсэн зөрчилд 2902.7 мянган төгрөгийг төсвийн орлогод төвлөрүүлэхээр Улсын ахлах байцаагчийн 2 акт тогтоож төгрөг, 4683.7 мянган төгрөгийн зөрчилд Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага, 8 зөвлөмж тус тус өглөө.

2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Дархан сумын 12-р сургууль, 26-р цэцэрлэгт санхүүгийн хяналт шалгалт, Дархан сумын Орхон сумын 8-р сургуульд дотоод аудитийг 2022-2023 оны үйл ажиллагааны баримтад хийж байна.

Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2022, 2023 оны баримтад дотоод аудитыг хийж, илэрсэн зөрчилд сонсох ажиллагааг явуулж байна.

Дархан-Уул аймаг дахь Дархан Политехник коллежийн даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 46 тоот албан бичгийн дагуу тус байгууллагын нэр бүхий 4 багш, ажилтанд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2, 16.1.3 дахь заалтад заасан мөнгөн тэтгэмж олгох эсэх асуудлыг нягтлан шалгаж дүгнэлт өгөх, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх зорилгоор төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох ажилтнуудаас асуулга, тодруулга авч ажиллан хариуг хүргүүлсэн.

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өимчит байгууллагуудад хөрөнгийн тооллого болон шилэн дансны мэдээллийн талаар зөвлөмж бэлтгэн цахимаар хүргэлээ. Мөн Төрийн албаны тухай хуулийн хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл, сайжруулах арга саналыг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т цахимаар хүргэсэн.

Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулж буй 7:4:10 “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”, “Дижитал шилжилт, виртуал орчинд ажиллах”, Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” сэдэвт онлайн сургалтад 9 албан хаагч тухай бүр нь хамрагдлаа.

Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь үйл ажиллагаандаа Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO9001:2016 стандартыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаатай холбогдуулан албан хаагчдад “Бүтээмжийн тухай ойлголт, зарим аргууд” сэдвээр сургалтыг Оргил Ундрах Эрдэм ХХК-ний зөвлөх, тэргүүлэх аудитор Ж.Чанцалням хийлээ.



Тус алба нь Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнийг баталгаажуулсан гэрчилгээг гардан авлаа. Гэрчилгээг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээний

хэлтсийн дарга Отгонбаяр болон Мон майнинг сертифицийшн ХХК-ны гүйцэтгэх захирал Г.Баярхүү нар гардуулан өглөө.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА